



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 10 өдөр

Дугаар А114Б

Улаанбаатар хот

Аймгийн арслан цол олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Үндэсний Их баяр наадмын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тулгар Төрийн 2232, Их Монгол Улсын 817, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 112, Ардын хувьсгалын 102 жилийн ой, Багахангай дүүрэг үүсэн байгуулагдсаны 34 жилийн ойн хүрээнд үндэсний бөхийн цол олгох 128 бөхийн барилдаанд 7 давж түрүүлсэн тул Төв аймгийн Заамар сумын харьяат “Дүнжингарав” дэвжээний бөх, Аймгийн заан Лхагвадоржийн Даваажамцад “АЙМГИЙН АРСЛАН” цол олгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД